



**ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ**

17042 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 2 дугаар хороо,
Чингисийн өргөн чөлөө, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
ерөнхий газар 4 давхар, Утас/Факс: (976) 7012 4949,
И-мэйл: info@habemt.gov.mn, Вэбсайт: www.habemt.gov.mn

2019.12.02 № 653
танай _____-ны № _____-т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ЭРҮҮЛ АХУЙН САЛБАР ХОРООНД

Журмын хэрэгжилтийг хангах тухай

“Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 02 дугаар сарын 14-ний А/64 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

Журмын 4.5.2-д “Холбогдох яамны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо нь энэ журмын 2.1-д заасан шалгуурыг үндэслэн энэ журамд заасан өөрийн харъяалах салбарын ангиллаар тав хүртэл аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж, дүгнэсэн дүн, холбогдох материалыг 03 дугаар сарын 01-ний дотор мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцлийн асуудал хариуцсан байгууллагад ирүүлнэ” гэж тусгасан.

Иймд салбарын “Эрүүл, аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага-2019” болзолт уралдааны эхний шатны шалгаруулалтыг зохион байгуулж шалгаруулалтын дүн, шалгарсан 5 хүртэлх байгууллагын материалыг 2020 оны 03 дугаар сарын 01-ний дотор Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд ирүүлнэ үү.

“Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах журам болон 100 онооны шалгуур үзүүлэлтийг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 12 хуудас.

ЗАХИРАЛ, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ
БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮНДЭСНИЙ
ХОРООНЫ ГИШҮҮН



М.ДАВААБАТ



МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/64

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага" шалгаруулах журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Алимаа/-т, журмын хэрэгжилтийг зохион байгуулахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв /М.Даваабат/-д тус тус даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хөдөлмөрийн сайдын 2013 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/61 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  С.ЧИНЗОРИГ



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2019 оны 12 дугаар сарын 14-ны
өдрийн 1/64 тоот тушаалын хавсралт

“ЭРҮҮЛ-АЮУЛГҮЙ АЖЛЫН БАЙРЫГ ЭРХЭМЛЭГЧ БАЙГУУЛЛАГА” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Үйлдвэрлэлийн орчин, ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, ажилтныг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин, бусад эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагаас явуулж буй үйл ажиллагаа, санаачлагыг урамшуулан дэмжих, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд энэ журмын зорилго оршино.

Хоёр. Шалгаруулах үзүүлэлт

2.1 “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулалтад оролцогч байгууллагыг дараахь багц үзүүлэлтээр шалгаруулна:

2.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт;

2.1.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, тэргүүн туршлага;

2.1.3 Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмжийн шаардлага, стандарт;

2.1.4 Ажилтны эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээ.

2.2 Томоохон аж ахуйн нэгж, байгууллагын бие даасан нэгж (тодорхой чиг үүрэг, эрх бүхий хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн этгээд) дангаараа “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулалтад оролцож болно.

Гурав. Бүрдүүлэх баримт бичиг

3.1 Шалгаруулалтад оролцох байгууллага нь энэхүү журмын 2.1-д заасан багц шалгуур үзүүлэлтийн дагуу дараахь материалыг бүрдүүлж харъяалах аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

3.1.1 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалтын шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

3.1.1.1 Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ /нотариатаар баталгаажуулсан хуулбар/, үйл ажиллагааны танилцуулга;

3.1.1.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц, зөвлөл, ажилтны талаар мэдээлэл, шийдвэр /Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дугаар тушаалын дагуу/;

3.1.1.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсөв, зарцуулалт;

3.1.1.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны стандартыг нэвтрүүлсэн байдал.

3.1.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, тэргүүн туршлагын хүрээнд:

3.1.2.1 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний тайлан, шинэлэг, дэвшилтэт, сайн арга туршлага;

3.1.2.2 Ажлын байрандаа эрсдэлийн үнэлгээ хийсэн болон хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгүүлсэн бол үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээ;

3.1.2.3 Өмнөх онд үйлдвэрлэлийн осолгүй ажилласан талаарх аймаг, дүүргийн мэргэжлийн хяналтын байгууллагын тодорхойлолт.

3.1.3 Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмжийн шаардлага, стандартын хүрээнд:

3.1.3.1 Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмж стандарт шаардлага хангасан талаар мэргэжлийн байгууллагаас гаргасан тодорхойлолт /тоног төхөөрөмжийн гэрчилгээ/ болон шаардлага дүгнэлтийн дагуу авсан арга хэмжээний тайлан, баримт, фото зураг;

3.1.3.3 Уул уурхайн чиглэлээр ажилладаг байгууллагын тухайд уул уурхайн үйл ажиллагааны стандарт, хүний эрүүл ахуйн аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд үзүүлдэг сөрөг нөлөөллийг багасгах, уурхайн хаалт, нөхөн сэргээлтгүйг хийж гүйцэтгэсэн байдал;

3.1.4 Ажилтны эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээний хүрээнд:

3.1.4.1 Харъяа аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсээс ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэл төлсөн эсэх талаар тодорхойлолт;

3.1.4.2 Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байдал, холбогдох байгууллагын тодорхойлолт;

3.1.4.3 Ажилтнуудаа ахуйн байр болон алжаал тайлах, чийрэгжүүлэх өрөө танхимаар хангаж буй байдал, авсан арга хэмжээний талаарх мэдээ, баримт (фото зураг, видео бичлэг болон бусад хэлбэрээр баталгаажуулсан);

3.1.4.4 Ажилтнуудаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтанд хамруулсан тайлан (фото зураг, сургалтын хуваарь), аюулгүй ажиллагааны зааварчилга өгсөн тэмдэглэл;

3.1.4.5 Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн онцлогт нь тохируулан ажлын тусгай хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн хангалт, мөрдөж буй жагсаалт, норм, дүрмийн дагуу ашиглаж буй байдалд хяналт хийсэн тайлан мэдээ.

3.2 Шалгаруулалтад оролцох байгууллага нь шалгуур үзүүлэлттэй холбоотой нэмэлт баримт бичиг өгч болно.

Дөрөв. Салбарын ангилал, шалгаруулалтын зохион байгуулалт

4.1 Шалгаруулалтыг дараахь салбарын ангиллаар зохион байгуулна.

4.1.1 Уул уурхай, олборлолт;

4.1.2 Барилга;

4.1.3 Боловсруулах үйлдвэрлэл;

4.1.4 Эрчим хүч;

4.1.5 Зам тээвэр;

4.1.6 Төрийн болон үйлчилгээний /боловсрол, эрүүл мэнд, худалдаа, үйлчилгээ, батлан хамгаалах, төрийн тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг салбар зэрэг/.

4.2 Энэхүү журамд заасан салбарын ангилал тус бүрээр 100 хүртэл ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага болон 100-аас дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага гэсэн 2 ангилал болгон шалгаруулалтад оролцуулна.

4.3 Харъяалах аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь "Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага" шалгаруулалтад оролцохоор ирүүлсэн материалыг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны дотор бүртгэн, хүлээн авна.

4.4 Аймаг, дүүргийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь бүртгэн хүлээн авсан материалыг 01 дүгээр сарын 30-ны дотор дараахь байгууллагад тус тус хүргүүлнэ.

а. 4.1.1-4.1.5-д хамаарах байгууллагын материалыг холбогдох яамны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороонд;

б. 4.1.6-д хамаарах байгууллагын материалыг харъяалах аймаг, дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлд.

4.5 Эхний шатны шалгаруулалт:

4.5.1 Аймаг, дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл нь энэ журмын 2.1-д заасан шалгуурыг үндэслэн аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж, дүгнэсэн дүн, шалгарсан гурав хүртэл байгууллагын материалыг 3 дугаар сарын 01-ний дотор мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцлийн асуудал хариуцсан байгууллагад ирүүлнэ.

4.5.2 Холбогдох яамны Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо нь энэ журмын 2.1-д заасан шалгуурыг үндэслэн энэ журамд заасан өөрийн харъяалах салбарын ангиллаар тав хүртэл аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж, дүгнэсэн дүн, холбогдох материалыг 03 дугаар сарын 01-ний дотор мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцлийн асуудал хариуцсан байгууллагад ирүүлнэ.

4.6 Хоёр дахь шатны шалгаруулалт:

4.6.1 Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллагын захирлын шийдвэрээр "Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага" шалгаруулах ажлын хэсгийг байгуулж ажиллуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, нийгмийн даатгал болон мэргэжлийн хяналтын байгууллага, холбогдох салбарын байгууллагын төлөөллийг оролцуулна.

4.6.2 Ажлын хэсэг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар хороо болон зөвлөлөөс ирүүлсэн материалыг энэ журмын 2.1-д заасан шалгуурыг үндэслэн 03 дугаар сарын 25-ны дотор сонгон шалгаруулж, дүнгээ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлнэ.

4.6.3 Ажлын хэсгийн гишүүд онооны дарааллаар салбарын ангилал тус бүрээр дүгнэгдсэн ахуйн нэгж байгууллага тус бүрээс эхний 3 байранд орсон байгууллагын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцсаны үндсэн дээр эцсийн сонгон шалгаруулалтыг хийж, дүнгээ гаргана.

4.7 "Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага"-ын шалгаруулалттай холбоотой зардлыг дараахь арга хэмжээнд зарцуулна:

4.7.1 шагнал, урамшууллын зардал;

4.7.2 сургалт, сурталчилгааны зардал;

4.7.3 зохион байгуулалтын зардал.

Тав. Шагнал, урамшуулал

5.1 Энэхүү журмын дагуу "Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага"-аар шалгарсан аж ахуйн нэгж байгууллагад салбарын ангилал болон ажилтнуудын тооноос хамааруулан дараахь өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнана.

5.1.1 Уул уурхай, олборлолтын салбарын "Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага"

100 хүртэл ажилтантай-1. Өргөмжлөл, цом

100-аас дээш ажилтантай-1. Өргөмжлөл, цом

5.1.2 Барилгын салбарын "Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага"

100 хүртэл ажилтантай-1. Өргөмжлөл, цом

100-аас дээш ажилтантай-1. Өргөмжлөл, цом

5.1.3 Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын "Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага"

100 хүртэл ажилтантай-1. Өргөмжлөл, цом

100-аас дээш ажилтантай-1. Өргөмжлөл, цом

5.1.4 Эрчим хүчний салбарын “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”

100 хүртэл ажилтантай-1. Өргөмжлөл, цом

100-аас дээш ажилтантай-1. Өргөмжлөл, цом

5.1.5 Зам тээврийн салбарын “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”

100 хүртэл ажилтантай-1. Өргөмжлөл, цом

100-аас дээш ажилтантай-1. Өргөмжлөл, цом

5.1.6 Төрийн болон үйлчилгээний салбарын “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”

100 хүртэл ажилтантай-2

Тэргүүн байр-1. Өргөмжлөл, цом, 4.0 сая төгрөг.

Дэд байр-1. Өргөмжлөл, цом, 3.0 сая төгрөг.

100-аас дээш ажилтантай-2

Тэргүүн байр-1. Өргөмжлөл, цом, 5.0 сая төгрөг.

Дэд байр-1. Өргөмжлөл, цом, 4.0 сая төгрөг.

5.2 “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар шалгарсан аж ахуйн нэгж байгууллагад холбогдох салбарын төрийн захиргааны төв байгууллагаас мөнгөн шагнал олгож болно.

5.3 “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар 2 дахь удаагаа шалгарч байгаа аж ахуйн нэгж, байгууллагад “Шилдгийн шилдэг” цом болон 6.0 /зургаа/ сая төгрөгийн мөнгөн шагнал гардуулна.

5.4 “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудад өргөмжлөлийг жил бүрийн 4 дүгээр сард гардуулна.

5.5 “Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага”-аар шалгарсан байгууллагуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, сайн туршлагыг олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилах, эмхтгэл болгон бусад аж ахуйн нэгж, байгууллагуудад

түгээн дэлгэрүүлэх ажлыг мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага зохион байгуулна.


5.5 Аймаг, дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл нь энэ журмын 4.5-д заасны дагуу харъяа аймаг, дүүргээс шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагыг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх ажлыг орон нутагтаа хариуцан зохион байгуулна.

5.6 Энэ журмын дагуу шалгарсан аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн жилдээ ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн сайн туршлагаа олон нийтэд сурталчилах үүрэг хүлээнэ.

5.7 Мэргэжлээс шалтгаалсан өвчин, хөдөлмөрийн нөхцөлийн асуудал хариуцсан байгууллага нь "Эрүүл-Аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага"-аар шалгарсан байгууллагуудын сайн туршлагыг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх талаар хийсэн ажил, зохион байгуулсан арга хэмжээний талаарх тайланг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хорооны хуралд тухайн оны гуравдугаар улиралд багтаан танилцуулна.

___оОо___

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн
төвийн захирлын 2019 оны 12 дугаар сарын 02-ны
өдрийн 1/2.43 дугаар тушаалын хавсралт



**“ЭРҮҮЛ-АЮУЛГҮЙ АЖЛЫН БАЙРЫГ ЭРХЭМЛЭГЧ БАЙГУУЛЛАГА”-ЫН
ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

Үзүүлэлт	Шалгуур	Оноо
НЭГ. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, зохион байгуулалт	Ажил олгогч нь ХАБЭА сургалтад хамрагдсан бол	3
	Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дугаар тушаалын дагуу ХАБЭА-н асуудал хариуцсан бүтэц, ажилтан, зөвлөл ажилладаг бол	3
	"Эрүүл, аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага" болох зорилт дэвшүүлэн, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангасан бол	3
	ХАБЭА, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг жил бүрийн төсөвтөө тусган хэрэгжүүлдэг бол	2
	ХАБЭА хууль тогтоомж, нийтлэг шаардлага, стандартын хэрэгжилт, ажлын байран дахь эрсдэлийн үнэлгээний дагуу авагдсан арга хэмжээний биелэлтэд дотоод хяналтыг тавьж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг авдаг бол	2
	Ажил олгогч нь ажлын байрны онцлогт нийцсэн дүрэм, журам, аюулгүй ажиллагааны заавар боловсруулан батлан мөрдүүлж хэвшсэн бол	2
	Ажилтнуудыг мэргэшүүлэх, чадавхижуулах шаардлагатай зардлыг төсөвтөө байнга тусгадаг бол	2
	Онцгой байдлын үед /гал түймэр, зуд, осол, голомтлод гарсан халдварт өвчин/ авран хамгаалах, анхны тусламжийн бэлэн байдлыг хангах арга хэмжээний төлөвлөгөөтэй, ажиллагсдыг сургаж бэлтгэсэн бол	1
	Ажилтнуудаа нийгмийн даатгалд бүрэн хамруулсан бол	1
	Ажилтнуудаа эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулсан бол	1
Ажилтнуудаа үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд хамруулсан бол	1	
	Нийт оноо	21
ХОЁР. ХАБЭА-н урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, тэргүүн туршлага	Ажлын байранд учирч болох аюул ослыг арилгах, хяналт тавих зорилгоор эрсдэлийн үнэлгээг тодорхой давтамжтайгаар хийдэг, баримтжуулдаг бол	3
	Эрсдэлийн үнэлгээг зохион байгуулахад ажилтнуудын оролцоог хангадаг бол	3
	ҮО болон осолд дөхсөн тохиолдол, хөдөлмөрийн чадвар алдалтыг судалж, бүртгэдэг, судалгааны дүнг ХАБЭА бодлого шийдвэрт ашигладаг бол	3
	Аюулыг арилгах болон эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлдэг, ХАБЭА бодлого шийдвэрт сайжруулалт хийдэг бол	3
	ХАБЭА-тай холбоотой асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд	2

	ажилтнуудаа татан оролцуулдаг бол	
	Ажилтнуудынхаа ажлын аюулгүй арга барил, дадлыг урамшуулдаг бол	2
	Хөдөлмөрийн сайдын 2016 оны А/33 дугаар тушаалын дагуу сургалт явуулж шалгалт авдаг бол	2
	Сургалтын өрөө танхимтай бол	2
	Ажлын байран дахь зааварчилгааг байнга өгдөг бол	2
	Ажилтнуудын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар санал бодлоо илэрхийлэх боломжийг бий болгох зорилгоор төрөл бүрийн арга хэрэгсэл /Саналын хуудас, саналын хайрцаг гэх мэт/-ийг ашигладаг бол	2
	Ажилтнуудаас гаргасан санал, санаачлалыг хэрэгжүүлэх зорилгоор аян, хөдөлгөөн, тэмцээн, уралдаан зэрэг төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулдаг бол	1
	ХАБЭА талаар байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээнд ажилтнуудын гэр бүл, түншлэгч, хэрэглэгчдийг оролцуулдаг бол	1
	Ажилтнуудын эрүүл аюулгүй ажиллах арга барил, зан үйлийг урамшуулах тогтолцоотой бол	1
	Ажилтнуудын сургалтын хэрэгцээг тодорхойлдог, хэрэгцээн дээр үндэслэн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажилтнуудаа тасралтгүй сурах боломжоор хангадаг бол	1
	Ажлын байранд ХАБЭА-н мэдээлэл, сурталчилгааны самбар тогтмол ажиллуулдаг бол	1
	Нийт оноо	29
Гурав. Үйлдвэрлэлийн орчин, барилга байгууламж, машин механизм, тоног төхөөрөмжийн шаардлага, стандарт	Цех, тасгийн ажлын байрууд нь эмх цэгц, хөдөлмөр зохион байгуулалт сайтай бол	2
	Машин механизм, тоног төхөөрөмжийг мэргэжлийн хяналтын байгууллагаар хянуулж зөвшөөрөл авч баталгаажуулсан бол	2
	Машин механизм, тоног төхөөрөмжийн бүтэц, хийц, хөдөлгөөнт хэсэг, удирдлага, дохиоллын систем, бүрдэл хэсэг /ажлын байр, гарц, шат, хашлага, хамгаалах хэрэгсэл/ нь аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан бол	2
	Машин механизм, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, тохируулгыг техникийн баримт бичигт заасан хугацаанд тогтмол хийж тэмдэглэл хөтөлдөг бол	2
	Ажлын байрны аюултай бүс болон тоног төхөөрөмжийн аюултай хэсгүүдэд анхааруулах тэмдэг, дохиолол, санамж тавигдсан бол	2
	Химийн хортой болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, цацраг, биологийн идэвхт бодисыг стандартын дагуу ашиглаж, хадгалдаг бол	2
	Ахуйн байр, хооллох өрөө нь хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт, ариун цэврийн шаардлагад нийцсэн бол	2
	Цахилгаан тоног төхөөрөмж нь удирдлага, дохиолол, хаалт, хамгаалалтай, гарч болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх хэрэгслээр тоноглогдсон бол	1
	Зориулалтын барилга байгууламжид үйл ажиллагаа явуулдаг бол	1
	Цахилгаан тоног төхөөрөмж нь газардуулга, газардуулгын даацын	1

	баталгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, цахилгаан ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг хангасан бол	
	Ажлын байр нь иж бүрэн агааржуулах системээр бүрэн хангагдсан бол	1
	Галын аюул ослын үед гал унтраах тусгай тоноглол, гарц, орцын зураглалыг гал гарч болзошгүй ажлын байр бүрд байрлуулан тогтмол ажиллагаатай байлгасан, ажилтнууд нь тоноглолыг ажиллуулж сурсан бол	1
	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байр нь тэдний хөдөлмөрлөх чадварт нь тохирсон бол	1
	Ажиллагсад болон үйлчлүүлэгсдэд зориулсан эрүүл ахуйн болон стандартын шаардлага хангасан ариун цэврийн өрөөгөөр хангагдсан бол-/Угаагуур 15-20 хүнд -1, суултуур 20 эмэгтэйд-1, 25 эрэгтэйд-1, усанд орох газар 10 хүнд -1/	1
	Ажиллагсдыг эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан ундны баталгаат усаар хангадаг бол	1
	Байгууллага нь ариутгал, халдваргүйтгэл тогтмол хийлгэдэг бол	1
	Ажилтнуудын хоолны аюулгүй байдалд хяналт тавьж, тэднийг илчлэг сайтай, эрүү хоол хүнсээр хангадаг бол	1
	Хөдөлмөрийн аюултай, хортой нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтныг хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүнээр хангадаг бол	1
	Ажилтнуудад зориулсан биеийн тамирын дасгал сургуулилтын танхим, тоног төхөөрөмжтэй бол	1
	Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн нэр төрөл, эдэлгээний хугацаа бүхий жагсаалтыг батлан мөрдүүлж ажилладаг бол	1
	Ажилтнуудыг ажлын нөхцөл, ажил үүргийн онцлогт тохирсон, эрүүл ахуйн чанарын шаардлага хангасан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр үнэ төлбөргүй хангадаг бол	1
	Ажлын тусгай хувцсыг угааж цэвэрлэх, ариутгах боломжоор хангасан бол	1
	Үйлдвэрлэлийн болон ахуйн хог хаягдлыг холбогдох хууль болон стандартын дагуу тээвэрлэн устгаж, хог хаягдлын цэг нь стандартын дагуу байрласан бол	1
	Байгууллагын хог хаягдлын цэгт цэвэрлэгээ тогтмол хийгддэг бол	1
	Нийт оноо	31
Дөрөв. Эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг сайжруулах арга хэмжээ	Ажлын байранд хөдөлмөрийн эрүүл ахуйн хэмжилт, үнэлгээ хийдэг бол	2
	Хэмжилтийн дүнг ажиллагсдад мэдээлдэг, зөвлөмж өгдөг бол	2
	Мэргэжлийн байгууллагаар ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэж, үнэлгээний дүнд үндэслэн хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлдэг бол	2
	Эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт тогтмол хамруулдаг бол	2
	Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүнг ажилтнуудад мэдээлдэг, ХАБЭА бодлого, шийдвэрт ашигладаг бол	2
	Ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгийн бүртгэл, өвчлөлийн мэдээ,	2

баримтын санг бий болгож хөтөлдөг бол	
Эмийн сан, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний цэгтэй болон шаардлагатай эм, тариа, ариутгалын боолт материалаар хангагдсан бол	2
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний талаарх тоон мэдээллийг холбогдох байгууллагуудад мэдээлдэг бол	2
Ажиллагсдыг эрүүлжүүлэх болон бялдаржуулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг бол	1
Хөдөлмөрийн аюултай, хортой нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтныг богиносгосон цагаар ажиллуулж, нэмэгдэл хөлс олгодог бол	1
Ажилтныг сувилах, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх арга хэмжээ авч ажилладаг бол	1
	НИЙТ ОНОО
	19
Нийт оноо	100